ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*Захиргаа, удирдлагын хэлтэс*

УЛААНБААТАР ХОТ
2023 он

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# *БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ*

## 1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэд байршсан 2022 оны жилийн эцсийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг хяналтад авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Монгол Улсын 4 хуулийн 49 заалт;
- УИХ-ын 7 тогтоолын 15 заалт;
- УИХ-ын байнгын хорооны 3 тогтоолын 3 заалт;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 6 заалт;
- Засгийн газрын 28 тогтоолын 42 заалт;
- Засгийн газрын хуралдааны 27 тэмдэглэлийн 43 заалт нийт 6 төрлийн 73 ***шийдвэрийн 158 заалтыг*** хяналтад авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. 2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн ***дундаж үнэлгээ 91.6 хувь*** б а й в .




Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 2 заалт, УИХ-ын 3 тогтоолын 5 заалт, Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 3 заалт, Засгийн газрын 10 тогтоолын 17 заалт, Засгийн газрын хуралдааны 4 тэмдэглэлийн 8 заалт ***нийт 5 төрлийн 20 шийдвэрийн 35 заалтыг шинээр хяналтад авсан*** бол 2022 оны 11 дүгээр сарын тайлангийн явцын үр дүнгээс Засгийн газрын 19 тогтоолын 21 заалт, Засгийн газрын хуралдааны 7 тэмдэглэлийн 9 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 2 заалт ***нийт 3 төрлийн 28 шийдвэрийн 32 заалтын хэрэгжилт*** зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авч холбогдох байгууллагууд хяналтдаа авсан, үр дүн гарч, тогтмолжсон шийдвэрүүдийн хасах саналыг хүргүүлснээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаас хас ч, дотоод хяналтдаа авахыг чиглэл болгосон байна.

2022 оны жилийн эцсийн тайлангийн үр дүнгээр чиг үүргийн хувьд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарахгүй 10 заалтыг “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” тэмдэглэгээ хийж, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болж, хэрэгжилтэд тодорхой үр дүн гарсан УИХ-ын 2 тогтоолын 5 заалт, тухайлбал (Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудын тухай,МУ-ын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай), бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон, дараагийн шатны шийдвэр гарсан, цаашид чиг үүргийн хувьд манай байгууллагад хамааралгүй болсон талаар дээд шатны шийдвэр

гарсан зэрэг 13, цаг хугацаа шаардсан, судалгаа тооцоолол хийх, шууд хэрэгжих боломжгүй 1 нийт 29 заалтыг тайлбарын хамт системд оруулан хяналтаас хасах саналыг тэмдэглэн хүргүүлсэн.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэд байршсан 73 шийдвэрийн 160 заалтаас Засгийн газрын 385 дугаар тогтоолын 3.3 дах заалт, 435 дугаар тогтоолын 4 дэх заалт давхардаж орсон тул 158 заалтаар хэрэгжилтийг тайлагнасан болно.

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаас хамаарч үр дүн гарахаар хүлээгдэж байгаа, хэрэгжилтэд ямар нэг өөрчлөлт ороогүй 10 заалт байна.

2022 оны сүүлийн хагас жилд гарсан шийдвэрийн үр дүн 2023 оны эхний улиралд багтан гарах, холбогдох байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан 6 заалтын хэрэгжилтийг “хэрэгжих шатанд” буюу 70.0 хувьтай байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 45 чиглэлийн хүрээнд байгууллагын нээлттэй, ил тод байдлыг хангах талаар үүрэг болгосон байна.

| д /д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл | Шийдвэрийн тоо | Хэрэгжилтийг тооцсон заалтын тоо | Бүрэн хэрэгжсэн (100%) | Үүнээс: Хэрэгжих шатанд (70%) | Хэрэгжилт хангалтгүй (30%) | Хэрэгжээгүй (0%) | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ) | Хэрэгжилтийн явцын дүн (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын хууль | 4 | 49 | 38 | - | - | - | 11 | **100.0%** |
| 2 | УИХ-ын тогтоол | 7 | 15 | 13 | - | - | - | 2 | **100.0%** |
| 3 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 3 | 3 | - | - | - | - | **100.0%** |
| 4 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг | 4 | 6 | 5 | - | - | - | 1 | **100.0%** |
| 5 | Засгийн газрын тогтоол | 28 | 42 | 15 | 21 | 1 | - | 5 | **81.1%** |
| 6 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 27 | 43 | 24 | 14 | - | - | 5 | **88.9%** |
| | **Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)** | **73** | **158** | **98** | **35** | **1** | **-** | **24** | **91.6%** |

*/Дэлгэрэнгүй тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан unelgee.gov.mn-д 2023.01.23-ны өдөр оруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А-1/156 дугаар албан бичгээр 3 хавсралт 87 хуудас материалыг ЗГХЭГазарт хүргүүлсэн/.*

## 2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгийн хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ – **81.7% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”** байна.

ТӨБЗГ нь хариуцан хэрэгжүүлэх 12 арга хэмжээний 11 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 1 арга хэмжээ (4.4.10.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар үүрэг хүлээсэн.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2021 онтой харьцуулахад хэрэгжилтийн үнэлгээний хувь 10-аар буурсан шалтгааныг авч үзвэл 3.2.7.5, 3.2.7.6 дугаар арга хэмжээг тавьсан зорилтод хүрэх зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч, Ковид 19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжилт төлөвлөсөн цаг хугацаанаас хойшлогдсон ялангуяа цаг хугацаа шаардсан бүтээн байгуулалтын ажлууд, 3.7.8.1 дүгээр арга хэмжээ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шууд хамаарах ажлыг гүйцэтгэсэн ч, хамтран хэрэгжүүлэгч байгууллагаас хамаарч үр дүн гарахтай холбоотой байна.







**<u>Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:</u>**

*Бодлого, арга хэмжээгээр харуулбал:*




| д/д | Хэрэгжилт | | Бүгд | Бодлого | |
|---|---|---|---|---|---|
| | | | | **Эдийн засаг** | **Засаглал** |
| 1 | Хяналтад авсан зорилтын тоо | | 5 | 2 | 3 |
| 2 | Хяналтад авсан арга хэмжээний тоо | | 12 | 3 | 9 |
| 3 | Үнэлгээний хувь | 100.0 хувь | 3 | - | 3 |
| 4 | | 90.0 хувь | 6 | - | 6 |
| 5 | | 70.0 хувь | 1 | 1 | - |
| 6 | | 50.0 хувь | - | - | - |
| 7 | | 30.0 хувь | 2 | 2 | - |
| 8 | | 0.0 хувь | - | - | - |
| 9 | **Хэрэгжилтийн хувь** | | **81.7 хувь** | **43.3 хувь** | **94.4 хувь** |

## Үндсэн хэрэгжүүлэх нэгжээр нь харуулбал:




*Үнэлгээний дүнгийн дэлгэрэнгүй:*

| д/д | Хэрэгжилт | | Бүгд | Хэлтэс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ТӨУЗХэлтэс | ТӨБАХэлтэс /МТА, ЗУХ/ | ТӨХШХэлтэс | ХЭЗХэлтэс /Бүх хэлтэс/ |
| 1 | Хяналтад авсан арга хэмжээний тоо | | 12 | 5 | 2 | 2 | 3 |
| 2 | Үнэлгээний хувь | 100.0 хувь | 3 | - | 1 | 2 | - |
| 3 | | 90.0 хувь | 6 | 2 | 1 | - | 3 |
| 4 | | 70.0 хувь | 1 | 1 | - | - | - |
| 5 | | 50.0 хувь | - | - | - | - | - |
| 6 | | 30.0 хувь | 2 | 2 | - | - | - |
| 7 | | 0.0 хувь | - | - | - | - | - |
| 8 | **Хэрэгжилтийн хувь** | | **81.7 хувь** | **62.0 хувь** | **95.0 хувь** | **100.0 хувь** | **90.0 хувь** |

***Шийдвэрлүүлэх асуудал /Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын түвшинд/***

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний:

- “4.1.4.5. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно” гэсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 4.1.4.1. Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбох арга хэмжээ нь ТӨБЗГазарт хамаарах заалт биш учраас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn–нээс хасалт хийлгүүлэх саналтай байна.

*/Дэлгэрэнгүй тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан unelgee.gov.mn-д 2022.11.25-ны өдөр оруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А-1/2350 дугаар албан бичгээр 4 хавсралт 27 хуудас материалыг ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн/.*

## 3. “АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд

хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан 1 зорилтын 2 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

2022 оны жилийн эцсийн байдлаар зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр ***"Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90.0 хувьтай*** байна.

5.2.18. Хөрөнгө оруулалт, өмчийн эрхийг хамгаалах, тогтвортой байдлыг хангах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгож, хувийн өмчийг бүрэн хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ. **Үр дүн – 90.0 хувь:**

– ***Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох:*** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр УИХ-д өргөн барьсан.

Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулж, УИХ-д өргөн барьсан бөгөөд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн;

5.2.19. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна. **Үр дүн – 70.0 хувь:**

- ***Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эхлүүлэх:*** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн "Нэмэлт хувьцаа гаргах тухай" 336 дугаар тогтоолоор нэр бүхий 25 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын 34 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжиж, олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

  "Төрийн банк" ТӨХХК-ийн хувьд холбогдох эрх бүхий байгууллагуудын шийдвэрүүд гарч, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд арилжаалах ажлыг эхлүүлсэн бөгөөд анхдагч арилжаа амжилттай зохион байгуулагдсан.

## 4. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний засаглалын бодлого бүлэгт тусгагдсан зорилт, арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ***"Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 95.0 хувьтай*** байна.

ТӨБЗГ нь хариуцан хэрэгжүүлэх 1 арга хэмжээ (МУТЖҮЧ - 5.1.1, ЗГҮАХ – 4.4.10, МУЖХТ – 4.1.19), 1 арга хэмжээ (МУТЖҮЧ – 5.1.1, ЗГҮАХ – 4.4.10, МУЖХТ - 4.4.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч (ХЗДХЯ) байгууллагаар үүрэг хүлээсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, дээд шатны байгууллагад өргөн баригдсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслүүд батлагдаагүй ч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох журам, дүрэм, аргачлалыг боловсруулан мөрдүүлж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлын дүн мэдээг хянан баталгаажуулах ажил бүрэн хийгдэж дуусаж Засгийн газрын хуралдаанд танилцуулахад бэлэн болсон байна.

### Мэдээллийн хүртээмж

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлийн хурлаар тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгуудыг хийсэн.
2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын албан хэрэгцээнд зориулж тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг байгууллагын дотоод сүлжээ Эйбл клоуд цахим системийн олон нийт цэсний байгууллагын үйл ажиллагаа, дотоод хяналтын цэс болон байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn-нд тус тус байршуулав.

### Бодлого, шийдвэрийн хэрэгжилт



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# *БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ*

## 1. БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Байгууллагын стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулан боловсруулж батлуулсан.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ***19 зорилт, 90 арга хэмжээ дунджаар 98.6 хувийн гүйцэтгэлтэй*** байв.

***Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:***



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьж, танилцуулснаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Эдийн Засгийн Байнгын хороонд шилжүүлсэн;

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн Засгийн Байнгын хороонд шилжүүлсэн.

Уг хуулийн шинэчлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Үндсэн хуульд нийцүүлэн тодорхойлж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчдийн эрх хэмжээг шинэчилж, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, харилцан уялдаа холбоог анхаарсан бөгөөд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхой тусгасан.



“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл, тогтоолын төслийн танилцуулга, үзэл баримтлал, зардлын тооцоо, хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөөний үнэлгээ зэргийг боловсруулж, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлсэн;

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол;

Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолуудыг хэлэлцүүлсэн.



“Төрийн байгууллагын албан ажлын хэрэгцээнд суудлын автомашин ашиглах нийтлэг журам”-ын төсөл болон ЗГХЭГ-ын даргын тушаалын төслийг боловсруулж, батлуулав.



Засгийн газрын 2022.04.13-ны өдрийн “Концессын гэрээ цуцлах тухай” 148 дугаар тогтоол



Засгийн газрын 2022.03.24-ний өдрийн “Хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” 124 дүгээр тогтоол

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 184 дүгээр тогтоолоор “Хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг;

“Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг 65 дугаар тогтоол;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гарч буй захиргааны баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах, хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 32 удаагийн хурлаас гарсан 777 шийдвэр (тогтоол – 739, тэмдэглэл - 38), байгууллагын даргын А тушаал 75, Б тушаал 119 нийт 194 тушаалын төсөл, байгууллагын хэмжээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай байгуулсан 17 гэрээний төслийг тус тус хянан баталгаажуулсан.

Хууль, шүүхийн байгууллагад үүссэн захиргааны 10, иргэний 17, эрүүгийн 11, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэж байгаа 3 нийт 41 хэрэг маргаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Засгийн газрыг төлөөлөн давхардсан тоогоор 86 удаагийн шүүх хуралд оролцож, 15 хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байна.

Эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор цаг үеийн болон шинэчлэн найруулагдсан хуулиудын онцлог зохицуулалтын талаар албан хаагчдад онлайн болон танхимын хэлбэрээр дараах сургалтуудыг зохион байгуулав.

- Нийгмийн даатгалын хуулийн тухай үндсэн ойлголт;
- Тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн тухай үндсэн ойлголт;
- Захиргааны ерөнхий хуулийн тухай ойлголт;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам;
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь;
- Мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт.

***Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр:***

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын шударга байдлын түвшний үнэлгээг 2 жил тутамд зохион байгуулдаг. 2022 оны “Шударга байдлын үнэлгээ”-гээр ***76.5 оноогоор*** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар улсын дүнгээр **XXIY байр**, агентлагийн дүнгээр **XIII байрт** эрэмбэлэгдлээ.






ТӨБЗГ нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу харьяа ТӨХЭтгээдийн мэдүүлгийн бүрдүүлэлтийг хариуцан чиглүүлж, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанд нь хяналт тавин, холбогдох тайлан мэдээг нэгтгэж, АТГ-д тайлагнадаг.

| Мэдүүлгийн бүрдүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Мэдүүлгийн бүрдүүлэлтэд хамрагдсан байгууллага (ТӨБЗГ, түүний харьяа ТӨХЭтгээд) | 79 | 76 | 50 | 50 | 50 | 50 | 44 |
| Тухайн жилд ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлсэн хүний тоо | 984 | 1195 | 701 | 694 | 692 | 787 | 626 |
| Тухайн жилд хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн мэдүүлгийн тоо | 22 | 66 | 40 | 48 | 18 | 45 | 29 |
| Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдлийн тоо | 1238 | 2987 | 1795 | 2781 | 2233 | 2776 | 1552 |
| АТГ-т хянуулсан албан тушаалд нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ) | 629 | 291 | 294 | 230 | 194 | 235 | 297 |

***Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бүртгэгдсэн мэдүүлэг, мэдэгдлийн тоо:***







***Төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн засаглалын чиглэлээр:***

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангах хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 46 компанийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контрактын гэрээ байгуулж, төрийн өмчит 29 хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/67 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн.

2022 онд нийт 72 компанийн 60 Төлөөлөн удирдах зөвлөлд нийт 188 асуудлаар 91 удирдамж, чиглэл өгч, биелэлтийг хангуулан ажилласан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 535 гишүүн ажиллаж байгаагаас хараат бус 169 гишүүн байна. Төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй 366 гишүүний 20 нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 117 Эрчим хүчний яам, 29 нь Сангийн яам, 10 нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 5 нь Барилга, хот байгуулалтын яам, 16 нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, 1 нь Байгаль, орчин аялал жуулчлалын яам, 3 нь Хууль зүй, дотоод хэргийн яам, 34 Зам, тээврийн хөгжлийн яам, 84 нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 47 нь бусад яам, агентлаг, орон нутгаас /давхардсан тоогоор/ томилогдон ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилох нийт 31 асуудлыг газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлж, 31 гишүүнийг чөлөөлж, 65 гишүүнийг томилсон байна.







Компаниудын хувьцаа эзэмшигчдийн хуралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг төлөөлөх төрийн өмчийн төлөөлөгчийг томилон, удирдамжийг баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд:

- "Монголын цахилгаан холбоо" ХК
- "Монгол шуудан" ХК
- Эрчим хүчний салбарын ТӨКомпаниуд
- "Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал" ХХК
- "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх, хувьчлах замаар үр ашгийг дээшлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан зохион байгуулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.



Төрийн өмчит компанийн хууль, эрх зүйн орчин, өмчлөл, засаглалын бүтцийг сайжруулах, цахим шилжилт хийж компаниудын мэдээллийг цахим платформын хүрээнд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх талаарх зөвлөмж боловсруулах, туслалцаа үзүүлэх чиглэлээр Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Төв Ази, Баруун Европын бүсийн Засаглалыг хариуцсан Дэд захирал, хатагтай Хестер Коутанч, Хөрөнгө оруулалтын зөвлөх хатагтай Лизавета Трахалина нартай уулзалт, яриа хэлцлийн дүнд эхний ээлжид төрийн өмчит хуулийн этгээдүүдийн цахим шилжилтийн хүрээнд нээлттэй мэдээллийн цахим сан бүхий цахим платформ байгуулах асуудалд туслалцаа үзүүлэхээр болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 46 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалт, Ерөнхий сайдын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар албан даалгаврын 5.3 дахь заалтын дагуу Төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газрын засаглал, ашигт ажиллагаа, ил тод байдал, хариуцлагыг сайжруулах, өмчлөлийн хэлбэрийг оновчтой болгох, өгөөж, нийгмийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, нэгдмэл удирдлагын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр санал боловсруулж Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам болон холбогдох ажлын хэсгүүдэд хүргүүлж, хурал уулзалт, хэлэлцүүлэгт танилцуулсан.



Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь төлөөлөгчтэй уулзалт хийж, зөвлөмж, арга зүйн зөвлөгөө авах чиглэлээр хамтран Дэлхийн банкны техникийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр, засаглалыг сайжруулах загвар төслийг боловсруулсан. Тус загвар төслийг компанийн засаглалын талаарх олон улсын сайн туршлагыг Монгол Улсын өнөөгийн нийгэм, эдийн засгийн онцлогт нийцүүлэх байдлаар боловсруулсан ба зөвлөмжийн дагуу манай улс төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудыг төвлөрсөн, нэгдмэл удирдлагаар хангах байдлаар хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзсэн.

Компанийн засаглалын Олон улсын туршлагыг судлах зорилгоор Сингапур улсын компанийн засаглалын сайн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, тус улсын Темасек холдинг корпорацитай холбох асуудлаар яриа хэлцэл хийсний дагуу Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын

төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, БНХАУ, Сингапур улстай санамж бичиг /гэрээ/ байгуулах бэлтгэл ажил хийгдсэн.



Компанийн засаглалын олон улсын туршлага, Төрийн өмчийн баялгийн сан, корпорацийн засаглал, үйл ажиллагааны бүтцийг Казакстаны САМРУК КАЗИНА, БНХАУ-ын SASAC, Сингапур улсын ТЭМАСЕК Холдинг зэрэг корпорациудын засаглал, үйл ажиллагааны бүтэц, өмчлөлийн байдал, Fortune global 500 буюу дэлхийн шилдэг 500 компанийн жагсаалт зэргийг судалсан.



Төрийн өмчийн удирдлага, менежмент болон олон улсуудын төрийн өмчийн талаарх бодлого, баримталж буй чиглэл, компанийн засаглал, санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх OECD, PWC, ADB (АХБ), World Bank, IDB, IMF (ОУВС), EBRD зэрэг олон улсын байгууллагуудаас эрхлэн гаргасан судалгаа, тайлантай танилцаж боловсруулалт хийсэн. Мөн Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, бие даасан байдлыг сайжруулах аргууд, Төрийн өмчит компанид нэгдмэл тайлагналыг нэвтрүүлэх арга зам, Төрийн өмчит компаниудын дотоод хяналтын тогтолцоог үнэлж, сайжруулах арга зам зэрэг сэдвээр судалгаа хийсэн ажлуудыг дурдаж болохоор байна.

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Компанийн Засаглалын хөгжлийн төвтэй хамтран, “Монгол шуудан” ХК /73%/, “Монголын цахилгаан холбоо” ХК /62%/, “Монголын төмөр зам” ТӨХК /59%/, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /60,5%/, “Амгалан дулааны станц” ТӨХК /52,6%/, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК станц” ТӨХК /84,6%/ зэрэг компаниудад засаглалын үнэлгээг хийлгэсэн. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 53.9 хувь байсан бол 64.8 хувьд хүрсэн үр дүнтэй байна.

Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу 2022 онд нийт 57 төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянасан.



***Өмч хувьчлалын чиглэлээр:***

Төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг “Орон сууц хувьчлах тухай” хуулийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Аймаг, нийслэлийн орон сууц хувьчлах товчоог байгуулах шийдвэр гаргаж, Орон сууц хувьчлах товчоодтой холбогдох хууль журмын хүрээнд хамтран ажиллалаа.




***“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 52 айлын орон сууц***

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах 52 айлын орон сууцыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсний дагуу үнэ төлбөргүй хувьчлах шийдвэрийг Засгийн газрын 2022 оны 87 дугаар тогтоолоор;

***“БЗӨБЦТСүлжээ” ТӨҮГ 9 айлын орон сууц***

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Говьсүмбэр аймагт байрлах 9 айлын орон сууцыг одоо амьдарч байгаа албан хаагчдад нь хувьчлах асуудлыг ТӨБЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Засгийн газрын 2022 оны 90 дүгээр тогтоолоор;

***“Монголросцветмет” ТӨҮГ 3 айлын орон сууц***

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 26 дугаар хуралдааны 25 дугаар тэмдэглэлээр “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 айлын орон сууцыг үйлдвэрийн газарт ажиллаж байсан ажилтан болон ар гэрийнхэнд нь үнэ төлбөргүй хувьчлах саналыг дэмжиж Засгийн газрын хуралдаанд тавьж шийдвэрлүүлэхээр;

***Гаалийн ерөнхий газар 20 айлын орон сууц***

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 26 дугаар хуралдааны 24 дүгээр тэмдэглэлээр Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 20 айлын орон сууцыг 18-ыг нь үнэ төлбөргүй, 2-ыг нь үнэ төлбөртэй хувьчлах саналыг дэмжиж Засгийн газрын хуралдаанд тавьж шийдвэрлүүлэхээр тус тус тогтсон.

***Хөрөнгийн хөдөлгөөн зохицуулалтын чиглэлээр:***

Давхардсан тоогоор 2146 хуулийн этгээдийн 81905 нэрийн 1,764.1 сая төгрөгийн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэж, төрийн өмчийн эд хөрөнгийн зохицуулалт хийсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ын дагуу Нийслэл болон 21 аймгийн төрийн өмчит 900 хуулийн этгээдийн “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 625 дугаар тогтоолоор хуулийн дүнг баталсан бөгөөд сайн үнэлгээгээр дүгнэгдсэн хуулийн этгээд болон албан хаагчдыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хүндэт жуух, өргөмжлөлөөр урамшуулсан.

Төрийн өмчийн байр, талбай, хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх гэрээг нийт 900 иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай байгуулж, 2.8 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүллээ.

Улсын төсөвт 2018-2022 онд төвлөрүүлсэн ***түрээсийн орлого***, иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хийсэн ***гэрээний тоо:***




### ***Дуудлагын худалдааны талаар:***

Төрийн өмчит 286 хуулийн этгээдийн 287 нэр төрлийн хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаж 888.9 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Дуудлага худалдааны орлого төвлөрүүлэлт**



***Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын талаар:***

Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2020 онд явуулахаар шийдвэрлэсэн боловч цар тахлын нөхцөл байдлын улмаас Засгийн газрын 2020 оны 46, 2021 оны 278 дугаар тогтоолоор 2 удаа хойшлуулж, 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн.

Улсын үзлэг, тооллогыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилттэй холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч 300.1 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогын ажлыг зохион байгуулах журам, аргачлал, зааврыг батлан мөрдүүлсэн. Тооллого явуулах журам, маягт, заавар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөрөнгийн зохицуулалттай холбоотой гарын авлагыг бэлтгэн хэвлүүлж, ашигласан, түүнийг цахимаар ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын pcsp.gov.mn цахим хуудасны тусламжтайгаар **burtgel.pcsp.gov.mn** хаягаар Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны тооллогын зөвлөгөө мэдээллийн сайтыг ажиллуулсан.



Төрийн болон орон нутгийн өмчийн нийт 6813 нэгж хамрагдсанаас хуулийн этгээдийн гэрчилгээтэй 5484 байгууллага байна. Эдгээрийн зохион байгуулалтын хэлбэрээр нь ангилан үзвэл төсөвт байгууллага 4733, хувьцаат компани 68, хязгаарлагдмал хариуцлагатай компани 99, төрийн өмчит болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 357, банк 3 (ХХК), төрийн тусгай сан 20, өрхийн эмнэлэг 204 байна. Улсын үзлэг, тооллогод нийт 91.7 их наяд төгрөгийн хөрөнгө хамрагдсанаас 39.7 их наяд төгрөгийн төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө байна.

| Өмчийн хэлбэр | Санхүүгийн тайлан гаргасан нэгжийн тоо | Нийт хуулийн этгээдийн тоо | Гэрчилгээгүй | |
|---|---|---|---|---|
| | | | ТЕЗ-ийн дотоод сан | төсөл |
| **Төрийн өмч** | 1273 | 1153 | 4 | 116 |
| **Орон нутгийн өмч** | 5341 | 4331 | 1010 | |
| **Нийт** | 6614 | 5484 | 1014 | 116 |



Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнгээр 34230 нэр төрлийн 7,940.2 тэрбум төгрөгийн *барилга* (төрийн өмч 14290 нэр төрлийн 3,474.0 тэрбум төгрөг, орон нутгийн өмч 19940 нэр төрлийн 4,193.2 тэрбум төгрөг), 54816 нэр төрлийн 1,496.6 тэрбум төгрөгийн *нийтийн эзэмшлийн талбай* (төрийн өмч 6703 нэр төрлийн 220.9 тэрбум төгрөг, орон нутгийн өмч 48113 нэр төрлийн 1,275.7 тэрбум төгрөг), 19325 нэгж талбар, 80,117 *га газар*,6,116.8 тэрбум төгрөг, 33941 нэр төрлийн 3,311.2 тэрбум төгрөгийн *байгууламж* (төрийн өмч 16435 нэр төрлийн 2,546.2 тэрбум төгрөг, орон нутгийн өмч 17506 нэр төрлийн 765.0 тэрбум төгрөг), хамрагдсан байна.

***Тээврийн хэрэгсэл:***

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогод хамрагдсан хуулийн этгээдэд нийт 2,539.3 тэрбум төгрөгийн балансын үнэ, 1,145.6 тэрбум төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 30161 ширхэг тээврийн хэрэгсэл хамрагдсан нь 40-57 хувийн элэгдэлтэй байна.



***Машин тоног төхөөрөмж:***

Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн тооллогод нийт 10,506.6 тэрбум төгрөгийн балансын үнэ, 4,855.6 тэрбум төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий машин тоног төхөөрөмж хамрагдсан нь дунджаар 54.5 хувийн элэгдэлтэй байна.



***Тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө:***

Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн тооллогод нийт 699.6 тэрбум төгрөгийн балансын үнэ, 319.6 тэрбум төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий тавилга эд хогшил хамрагдсан нь дунджаар 54 хувийн элэгдэлтэй байна.



***Худаг услалтын систем:***



Төрийн болон орон нутгийн өмчийн дүнгээр нийт 18946 ширхэг, 206.0 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий худаг тоологдсоны 67.2 тэрбум төгрөгийн худаг нь барилга байгууламж дансанд, 138.8 тэрбум төгрөгийн худаг нь бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна. Төрийн өмчийн худаг 2169 ширхэг, 48.7 тэрбум төгрөгийн, орон нутгийн өмчид 16677 ширхэг, 157.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий худаг тоологдсон.



Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогод нийт 15.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий 241 ширхэг услалтын систем хамрагдсан байна. Үүний нийт 1,6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 32 ширхэг услалтын систем төрийн өмчид, 13.3 тэрбум төгрөгийн 209 ширхэг услалтын систем, усан сан орон нутгийн өмчид тоологдсон байна.

## Түүх соёлын дурсгалт зүйлс:

| № | [illegible] | [illegible] | | | |
|---|---|---|---|---|---|
| # | Төрийн байгууллага | Байгууллагын тоо | Дэсийн тоо | Тоо ширхэг | Нийт үнийн дүн төгрөг |
| 1 | [illegible] | 3 | 28 | 28 | 1,210,608.92 |
| 2 | Боловсрол, шинжлэх ухааны яам | 8 | 1109 | 1109 | 2,252,306.54 |
| 3 | [illegible] | 2 | 698 | 1422 | 858,890.11 |
| 4 | Сангийн яам | 2 | 45 | 49 | 7,348.33 |
| 5 | Соёлын яам | 13 | 21238 | 21243 | 76,863,254.63 |
| 6 | [illegible] | 1 | 8 | 8 | 275.00 |
| 7 | [illegible] | 1 | 5 | 5 | 3,400.00 |
| 8 | Гадаад харилцааны яам | 1 | 4 | 4 | 86,193.14 |
| | Нийт | 31 | 23340 | 23869 | 80,983,482.87 |
| | [illegible] | 300 | 48965 | 60868 | 40,714,316.43 |
| | [illegible] | 331 | 72305 | 84737 | 121,697,798.30 |

Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогоор 331 байгууллагын үндсэн хөрөнгийн ***“түүх соёлын дурсгалт зүйлс”*** дансанд бүртгэлтэй 72305 дэсийн, 84737 ширхэг, 121,697.79 сая төгрөгийн үзмэр хамрагдсан байна.

## Биет бус хөрөнгө:

| Нэр | [illegible] | | |
|---|---|---|---|
| | Нийт балансын үнэ | Нийт хуримтлагдсан элэгдэл | Нийт үлдэгдэл үнэ |
| Орон нутгийн | 1,327,598.87 | 41,234.38 | 1,286,364.48 |
| Төрийн | 17,204,616.76 | 243,622.93 | 16,960,993.83 |
| Нийт | 18,532,215.63 | 284,857.32 | 18,247,358.31 |

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор нийт 18.5 их наяд төгрөгийн тэрбум төгрөгийн балансын үнэ, 284.8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий биет бус хөрөнгө хамрагдлаа.

## Оюуны өмчийн бүртгэл:

| Оюуны өмчийн ангилал | Төр | Орон нутаг |
|---|---|---|
| Шинэ бүтээл | 76 | |
| Ашигтай загвар | 65 | |
| Бүтээгдэхүүний загвар | 5 | |
| Барааны тэмдэг | 90 | 59 |
| Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн | 765 | 6 |
| Нийт | 1002 | 65 |

Оюуны өмчийн газрын “Оюуны өмчийн мэдээллийн нэгдсэн сан”-д Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшиж байгаа Аж үйлдвэрийн өмчийн эрхэд хамаарах шинэ бүтээл 76, ашигтай загвар 65, бүтээгдэхүүний загвар 5, барааны тэмдэг 149, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн 771 бүтээл бүртгэлтэй байна.

## Үндсэн сүргийн мал амьтад:

| № | [illegible] | Малын тоо | | | | | | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хонь | Ямаа | Үхэр | Тэмээ | Морь | Сарлаг | |
| | Нийт дүн | 8672 | 1967 | 1583 | 118 | 80 | 990 | 13410 |

## Гадаад улсад байгаа монгол улсын төрийн өмч:

Монгол Улсаас гадаад улсад байгаа 48 Элчин сайдын яам байгаа бөгөөд улсын үзлэг тооллогоор нийт гадаадад суугаа дипломат төлөөлөгчдийн газрын нийт 146,121,698.9 ам долларын хөрөнгө тооллогод хамрагдсанаас эргэлтийн бус хөрөнгө 98.48 хувийг эзэлж байна. Дипломат төлөөлөгчдийн газрын эзэмшилд төрийн өмчийн 134.8 сая ам долларын балансын үнэ бүхий нийт 97 ширхэг барилга байгууламж байна.

Мөн 138 нэрийн 55.6 сая мянган ам.долларын нийтийн эзэмшлийн хөрөнгө, 593.1 мян ам.долларын 14 ширхэг тээврийн хэрэгсэл, 2.1 сая ам.долларын 2879 нэрийн машин, тоног төхөөрөмж, 275 нэр төрлийн 23,8 мянган ам долларын үнэт зүйлс тооллогод хамрагдсан.

***Төрийн хяналт шалгалтын чиглэлээр:***



Төрийн өмчийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг 35, системийн хяналт шалгалтыг 11, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 10, Засгийн газрын шийдвэр болон иргэний гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 6 нийт 62 хуулийн этгээдэд батлагдсан удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн байна.

Хяналт шалгалтыг санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч 4, Улсын байцаагч 2, мэргэжилтэн 1 нийт 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 17 аймагт давхардсан тоогоор хуанлийн 370 хоног, ажлын 74 өдөр, нэг албан хаагч дунджаар 422 цаг томилолтоор ажилласан байна.

Хяналт шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн тоо, зөрчлийн дүн: **/2016-2022 он/**





***Зөрчлийг эрх зүйн актаар нь авч үзсэн үзүүлэлт, зөрчлийн дүн***:



| Д/д | Хуулийн этгээд | Тогтоолын он/дугаар | Зөрчлийн дүн/төгрөг | Тусгай тэмдэглэл |
|---|---|---|---|---|
| 1 | "Төв АЗЗА" ТӨХК | 2022/226 | **197.6 сая** | Төлөвлөгөөнд тусгагдаагүй зардаоыг санхүүжүүлсэн, Худалдан авалтын хууль тогтоомж зөрсөн, Түрээсийн төлбөр улсын төсөвт төвлөрүүлээгүй |
| 2 | - "Өвөрхангай АЗЗА" ТӨХК | 2022/282 | **242.04 сая** | Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлдсэн, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн, ЗГ-ын 43 тогтоолыг зөрчиж баярын ёслолын зардал гаргасан, түрээсийн төлбөр улсын төсөвт төвлөрүүлээгүй, барилга байгууламжийн элэгдэлийг буруу тооцсон |
| 3 | "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ | 2022/332 | **73.7 сая** | Төлөвлөгөөгүй худалдан авалт хийсэн, Газар эзэмших, ашиглах эрхээ үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй буюу 2020 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлж газа, Түрээсийн төлбөр улсын төсөвт төвлөрүүлээгүй |
| 4 | "Талын зам" ТӨХК | 2022/333 | **226.1 сая** | Төлөвлөгөөнд тусгагдаагүй зардаоыг санхүүжүүлсэн, Худалдан авалтын хууль тогтоомж зөрсөн, Хувь хүний албан татвар дутуу суутган авсан |
| 5 | "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК | 2022/334 | **410.0 сая** | Худалдан авалтын хууль тогтоомжийг зөрчсөн, газар эзэмших эрхийг баталгаажуулж аваагүй,эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй |
| 6 | Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК | 2022/397 | **1их наяд 233 сая** | Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгаланд танилцуулж Засгийн газрын 2022.11.30-ний өдрийн хуралдааны 57 дугаар тэмдэглэл албажсан. Хяналт шалгалтын тайланг боловсруулан 99 хуудас бүхий тайланг Сангийн сайдад А-1/1858 тоот албан бичгээр хүргүүлсэн. |
| 7 | "Багануур АЗЗА" ТӨХК | 2022/398 | **31.4 сая** | Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлдсэн, Худалдан авалтын хууль тогтоомж зөрчсөн |
| 8 | Хөтөлийн Цемент шохой ХК | 2022/386 | **43.4 тэрбум** | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж |
| | **НИЙТ ДҮН** | | **1 их наяд 278 тэрбум** | |

Хяналт шалгалтын үр дүнгээр зөрчил дутагдлыг арилгах, төрийн өмчийн үр өгөөжийг дээшлүүлэх, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх зорилгоор хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлт 10 хуулийн этгээдэд 70.0 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дараах байгууллагуудад хэрэгжүүлэн ажиллав.



***Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлын зохион байгуулалтын чиглэлээр:***



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т заасан ТӨБЗГ-ын дарга, орон тооны бус гишүүд батлагдсан "ХУРАЛДААНЫ ДЭГ"-ийн дагуу хуралдаж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тус байгууллагын хариуцан шийдвэрлэхээр заасан төрийн өмчийн асуудлыг хэлэлцэн хамтын шийдвэр гарган ажиллаж байна.

***Хуралдааныг 2021 онтой харьцуулвал:***




2022 онд 32 удаа хуралдаж, 739 тогтоол, 38 тэмдэглэл нийт 777 шийдвэрийн төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, менежментийн чиглэлээр 230 шийдвэр, хөрөнгийн хөдөлгөөн зохицуулалтын чиглэлээр 536 шийдвэр, төрийн хяналт шалгалтын чиглэлээр 10, хууль эрх зүйн чиглэлээр 1 шийдвэр тус тус гарсан байна.

***Хуралдааны шийдвэрийг холбогдох хэлтэсээр нь харуулвал:***




Хуралдааныг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.



Төрийн өмчийн бүргэл, ашиглалт, хөрөнгийн хөдлөл, зохицуулалтын чиглэлээр нийт 521 тогтоол, 15 тэмдэглэл гарсан бөгөөд тогтоолын агуулгын дэлгэрэнгүйг дараах хүснэгтээс харж болно:

| № | АГУУЛГА | ТОО |
|---|---|---|
| 1. | Хууль эрх зүйн акт /журам/ | 2 |
| 2. | Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн тооллогын дүн | 1 |
| 3. | Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай | 1 |
| 4. | Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай | 75 |
| 5. | Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай | 17 |
| 6. | Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай | 105 |
| 7. | Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай | 101 |
| 8. | Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай | 43 |
| 9. | Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай | 169 |
| 10. | Үндсэн хөрөнгө данснаас хасч орон нутгийн өмчит бүртгэх зөвшөөрөл олгох тухай | 11 |
| 11. | Бусад | 11 |
| | **Нийт** | **536** |

Төрийн өмчийн хяналт, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 10 тогтоол, хууль эрх зүйн хэлтсээс тогтоолд өөрчлөлт оруулах тухай 1 тогтоол гарсан байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, менежмент, засаглалын чиглэлээр нийт 207 тогтоол, 23 тэмдэглэл гарсан тогтоолын агуулгын дэлгэрэнгүйг дараах хүснэгтээр харуулвал:

| № | АГУУЛГА | ТОО |
|---|---|---|
| 1. | Төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөх | 35 |
| 2. | Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах, тодотгол хийх тухай | 53 |
| 3. | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын биелэлтийн тухай | 49 |
| 4. | Зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай, дүрэмд өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах тухай | 20 |
| 5. | Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж буй гишүүдийг чөлөөлөх, томилох тухай | 33 |
| 6. | Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж буй гишүүдийг чөлөөлөх, томилох тухай /тэмдэглэл нэмэлтээр гарах/ | 4 |
| 7. | Хариуцлага тооцох | 3 |
| 8. | Өмч хувьчлал | 4 |
| 9. | Ногдол ашгийн тухай | 3 |
| 10. | Нэмэлт хувьцаа гаргах тухай | 4 |
| 11. | Төрийн өмчит хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай | 5 |
| 12. | Хуулийн этгээдийн бусад асуудал | 17 |
| | **Нийт** | **230** |

***Шийдвэрийн ил тод байдал:***

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Хуралдааны дэг шинэчлэн батлах тухай” 53 дугаар тогтоолын 5.16-д заасныг нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор шийдвэрийг байгууллагын цахим хаягт цаг тухайд байршуулж байна.





### ***Хүний нөөцийн чиглэлээр:***

2022 онд нийт 49 албан хаагчтайгаар ажилласан.

ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛЛААР



Удирдах албан тушаалтан – 9



Төрийн захиргааны албан хаагч – 31



Төрийн үйлчилгээний албан хаагч – 9

40

АЛБАН ТУШААЛЫН АНГИЛЛААР

Тэргүүн түшмэл – 1
Ахлах түшмэл – 5
Дэс түшмэл – 34

ХҮЙСЭЭР

Эрэгтэй – 20

Эмэгтэй – 29

5 албан тушаалд 5 орон тооны захиалга өгч сул орон тоог бүрдүүлэн ажиллав.

### ***Нийгмийн баталгааг хангах чиглэлээр:***



Албан хаагчдыг ажлын байранд чадавхжуулах зорилгоор сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг давхардсан тоогоор нийт 96 албан хаагчдад 22.8 сая төгрөг;



Ар гэрийн гачигдал тусламж дэмжлэгийг нийт 11 албан хаагчдад 7.3 сая төгрөг;

2022 оны үйл ажиллагааны давсан орлогоос нийт 49 албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж 62.0 сая төгрөг, 13 дахь сарын цалин, үр дүнгийн урамшуулалд 104.0 сая төгрөгийг тус тус олгосон.

### ***Сургалт:***

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх 28 төрлийн сургалтыг давхардсан тоогоор нийт 412 албан хаагч хамрагдаж, төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай дүгнэгдлээ.



412

***28 төрлийн сургалт***

***Биелэлт 100.0 хувь***

Төрийн албаны тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 37/33 дугаар тушаалаар “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг баталсан. 2022 онд Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад дараах чиглэлээр нийт 19 албан хаагч хамрагдлаа.

1. Тэргүүн түшмэлийн багц сургалтад – 1;
2. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад -1;
3. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад – 4;
4. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад – 5;
5. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад – 8.

***Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:***



Монгол Улс дахь Оросын үл хөдлөх хөрөнгийг зохицуулах ажлын хоёрдугаар үе шатанд хамрагдах газар ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийн жагсаалт, хэмжээ, хаяг зэрэг мэдээллийг нягталж, газар ашиглах эрхийн зориулалт (дипломат болон энгийн тусгай зориулалттай)-ыг нэг бүрчлэн тулгах, улсын бүртгэлд хамруулах бэлтгэл ажлыг ханган ажилласан. ОХУ-ын маргаантай өмчийн асуудлаарх хоёр талын Ажлын хэсгийн хурлыг Улаанбаатар хот, Москва хотод тус тус зохион байгуулж, үр дүнг Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит 24 дүгээр хуралдаанд танилцуулсан. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөх, Монгол Улсад байгаа ОХУ-ын өмчийн маргаантай эд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх үл хөдлөх хөрөнгө, газрын эрхийн тоо хэмжээ, заагийг тогтоох, өмчлөх эзэмших эрхийг нягтлах зорилгоор хяналтын буюу техникийн үзлэгийн дүнгээр акт дүгнэлт гаргах ажил үргэлжилж байна.



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Хуралдааны 45 дугаар тэмдэглэл:

“ ... Хоёрдугаар байрны түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болж буйтай холбогдуулан байрыг түрээслэгчээс хүлээн авах явцтай танилцаад “ЦРЭ” компанитай үүссэн өр төлбөрийн асуудлаар Монголын талд ашигтай хувилбараар хэлэлцээ хийх, өр төлбөргүйгээр эцэслэн шийдвэрлэх, байрыг хүлээн авах чиглэлээр ажиллахыг Гадаад харилцааны сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан.

Элчин сайдын яамны Хоёрдугаар байрыг “ЦРЭ” компаниас 9 дүгээр сарын 29-ний өдөр албан ёсоор актаар хүлээн авсан.



ЭСЯ-ны 2 дугаар байрыг хүлээн авахад үүссэн асуудлыг шийдвэрлэх, ашиглах, түрээслэх нөхцөл шалгуур, түрээсийн гэрээ байгуулахад түрээслэгчид тавих шаардлага зэргийг тодорхойлон Гадаад харилцааны яаманд танилцуулсан.



Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойд зориулсан дугаар №32 сэтгүүлд Агентлагийн даргын илтгэх нийтлэлийг боловсруулж, “Монгол улс дахь өмч хувьчлал /1991-1996/ ба АНУ-ын дэмжлэг туслалцаа” сэдэвт өгүүллийг хэвлүүлсэн.







БНХАУ-ын Төрийн өмчийн хяналт, зохицуулах хороотой Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга нарын удирдах түвшний албан хаагчдын хүрээнд "Хамтын ажиллагааны санамж бичгийн бэлтгэл ажлыг хангах тухай" онлайн хурал зохион байгуулав.

***Байгууллагын санхүү төсвийн чиглэлээр:***




2022 онд 3,360.7 сая төгрөгийн төсөв батлагдаж (тодотголоор 1,967.7 сая болж өөрчлөгдсөн), төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажилласнаар 1,720.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 87.5 хувийн зарцуулалттай, 12.5 хувийн хэмнэлттэй ажилласан.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөгөөр 582,248.8 сая төгрөг үүнээс ирээдүйн өв санд 535,148.8 сая төгрөг, ногдол ашиг 45,500.0 сая төгрөг, түрээсийн орлого 1,600.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2022 оны гүйцэтгэлээр төсөвт төвлөрүүлсэн орлого 473,373.4 сая төгрөг үүнээс ногдол ашиг 469,631.9 сая төгрөг, түрээсийн орлого 2,582.5 сая төгрөг, дуудлага худалдааны орлого 888.9 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөний биелэлт 81.3 хувиар биелсэн байна.



**Төлөвлөгөөгөөр 582,248.8 сая төгрөг**




**Гүйцэтгэлээр 473,373.4 сая төгрөг**




2022 оны үндсэн үйл ажиллагааны давсан орлого 103,410.6 мянган төгрөгөөс албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэг болгон 62.0 сая төгрөг олгосон.

2021 оны санхүүгийн тайланд хийсэн төрийн аудитын зөвлөмжийн биелэлт 90.0 хувь, актын биелэлт 75.0 хувьтай байна.

***Улсын төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр:***

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 1.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн гүйцэтгэхээр тусгагдаж, холбогдох бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тендерийг зарлан гүйцэтгэгчийг шалгаруулсан байсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын

29-ний өдөр батлагдсантай холбоотой Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт орсноор батлагдсан төсөв нь хасагдсан тул гэрээ байгуулах боломжгүй болсон.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас байгууллагын 2023 оны төсвийн урсгал зардлаар уг зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорьж, шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийн зардлыг төсвийн төсөлд тусгаж, саналаа Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

Уг төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлүүлэх арга хэмжээний хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Сангийн яаманд тус тус хүсэлт хүргүүлсэн.

***Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:***

2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нийт 5917 албан бичиг ирснээс 3378 нь хариутай, 2539 нь хариу өгөх шаардлагагүй албан бичиг байв. Хариутай 3378 албан бичгээс 3301 буюу 97.7 хувь нь шийдвэрлэгдсэн, 10 буюу 0.3 хувь нь хяналтад, 67 буюу 2.0 хувь нь хугацаа хэтэрсэн байна. Шийдвэрлэсэн 3301 албан бичгийн 1532 буюу 45.4 хувь нь хугацаандаа, 1769 буюу 52.4 хувь нь хугацаа хоцорч шийдвэрлэгдсэн байв.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас нийт 2617 албан бичгийг холбогдох байгууллага, хуулийн этгээдэд хүргүүлсэн.

2022 онд Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, албаны албан хаагчдаас 400 баримт материалыг хүлээн авч, хадгаламжийн нэгж үүсгэлээ.

Архивын хадгаламжийн нэгжээс лавлагаа үйлчилгээ үзүүлэх хүрээнд 24 баримтыг ашиглалтад бүртгэлээр олгож, 1660 хуудас бүхий 255 баримтад “Хуулбар үнэн” тухай тэмдэглэгээ хийж баталгаажуулсан байна.

***Өргөдөл, гомдлын талаар:***

2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэд, хуулийн этгээд, албан хаагчдаас тус байгууллагад нийт 233 өргөдөл, гомдлыг ирүүлсэн бөгөөд тэдгээрээс 228 буюу 99.5 хувь нь шийдвэрлэгдсэн, 1 буюу 0.4 хувь нь шийдвэрлэх хуулийн хугацаа хоцорсон, 5 буюу 2.1 хувь нь хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхээр холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна. Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын 131 буюу 57.5 хувь нь хугацаандаа, 97 буюу 42.5 хувь хугацаа хоцорч шийдвэрлэсэн байв.



***Мэдээлэл технологийн чиглэлээр:***

Байгууллагын https://pcsp.gov.mn мэдээллийн сайт, фэйсбүүк хуудсанд өдөр тутмын үйл явдалтай холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр нийтэлж, сурталчлан, ил тод байдлыг хангаан ажилласан. Төрийн өмчийн улсын үзлэг тооллогын ажилд зориулж https://burtgel.pcsp.gov.mn/ цахим хуудсыг хийж ашиглалтад оруулсан.

Байгууллагын хэмжээнд Эйбл клоүд дотоод цахим сүлжээг ашиглаж, шинээр томилогдсон 16 албан хаагчдад хэрэглэгчийн эрх үүсгэж, 1 хэрэглэгчийн эрхийг хассан.

Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 32 албан хаагчдад тоон гарын үсэг авах ажлыг зохион байгуулан ажилласан.

-----o O o-----

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2022.12.31 Улаанбаатар хот

***Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр:***

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх 28 төрлийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 412 албан хаагч хамрагдаж, төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай дүгнэгдлээ. 2022 оны байдлаар албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд нийт 22,876,500 төгрөгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан.





***Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр:***

Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол болон "Байгууллагын дотоод журам"-д заасны дагуу буцалтгүй тусламж, албан хаагчдын гүйцэтгэлийн тайлангийн үр дүнгийн урамшууллыг олгосон. Буцалтгүй тусламж, дэмжлэгт 11 албан хаагч хамрагдаж 7.3 сая төгрөг, ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулалд 62.0 сая төгрөгийг тус тус зарцууллаа.

Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр компьютер тоног төхөөрөмж худалдан авахад 108,292,886 сая төгрөг төсөвлөн зарцуулсан бол Төрийн банканд орон сууцны ипотекийн 6 хувийн зээлд хамруулахад дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийг хүргүүлж, 2 албан хаагч зохих журмын дагуу зээл судлуулан орон сууцтай болсон байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу байгууллагын нийт албан хаагчдыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд Улсын нэгдсэн хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран зохион байгуулж, насны бүлгээс хамааран 35-аас доош насны 12 албан хаагч, 35-аас дээш насны 37 албан хаагч тус тус хамрагдлаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан 55 ахмадад сар шинийн баяр, ахмадын баярыг тохиолдуулан 5.5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон.

-----o O o-----

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

# *БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ*

## 1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Төрийн байгууллагын цахим ил тод байдлыг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийт үр дүнг улсын хэмжээнд тооцоолсноор цаашид Засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх хөшүүрэг болох зорилготой. Индексийн гол зорилтууд нь Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх, үр дүнг өмнөх жилтэй харьцуулах, цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах юм.

2022 онд улсын түвшинд цахим ил тод байдлын ерөнхий үр дүн улсын хэмжээнд ***63.1 хувь*** гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал “сул” түвшинд үнэлэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь 2022 онд байгууллагын цахим ил тод нээлттэй байдлын үнэлгээгээр нийт 93 байгууллагаас ***65.9 хувиар XX байрт,*** агентлагуудаас ***VIII байрт*** тус тус эрэмбэлэгдэж, ***“хангалттай”*** түвшинд дүгнэгдсэн байна.

2022 онд Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) 6 төрлийн 93 төрийн байгууллагын албан ёсны цахим хуудаст хандалт хийж 35 шалгуур үзүүлэлтийн дагуу 150 асуулт/үзүүлэлтийг ашиглан цахим ил тод байдлын индексийг хэмждэг. 2022 онд цахим ил тод байдлын ерөнхий индекс 63.1 хувь гарсан нь байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд байна гэж irim судалгааны хүрээлэнгээс дүгнэжээ.










Төрөөс мэдээллийг ил тод болгох үйл явц нь зөвхөн төрийн үйл ажиллагааны үр дүнд бус ***мэдээллийг ил тод болгох орчин бий эсэх (i),*** түүнийг хэрэгжүүлэх төрийн ***байгууллагын чадамж байгаа эсэх (ii),*** үүний үр дүнд ***иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн хялбар, хүртээмжтэйгээр хүрч буй эсэх (iii)*** үйл явцыг цогцоор үнэлэх юм.

Индексийн үзүүлэлтийг байгууллага бүр өөрийн давуу болон сул талыг танин мэдэхийн тулд харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлана. Энэхүү индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглах юм.

***Байгууллагын төрлөөр үр дүнг өмнөх жилтэй харьцуулсан харьцуулалт:***



| # | Байгууллагын төрөл | 2021 оны индекс | 2022 оны индекс | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын Их Хурал | 64.8% | 66.6% | 1.8% |
| 2 | Хэрэгжүүлэгч агентлагууд | 59.5% | 62.5% | 3.0% |
| 3 | Тохируулагч агентлагууд | 63.9% | 61.2% | -2.7% |
| 4 | Аймгуудын ЗДТГ | 58.4% | 65.6% | 7.2% |
| 5 | Дүүргүүдийн ЗДТГ | 61.2% | 62.7% | 1.5% |
| 6 | Парламентын харьяа байгууллагууд | 59.7% | 64.5% | 4.8% |
| Ерөнхий дундаж | | 60.2% | 63.1% | 3.3% |

***Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал:***

Судалгаанд хамрагдсан 26 хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлын дундаж 62.5 хувь буюу өнгөрсөн онтой харьцуулахад 6.8 хувиар өссөн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим ил тод байдлын хувьд 2019 онд 0.624, 2020 онд 45.6 байсан бол ***2022 онд 65.9 хувь буюу "хангалттай"*** түвшинд гэж үнэлсэн байна.

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал 2022

| № | Байгууллагууд | Цахим ил тод байдлын индекс | Хэрэглэгчийн үнэлгээ | Байгууллагын хуудас | Цахим хэрэгслийн байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | 72.8% | 78.0% | 79.8% | 59.8% |
| 2 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 70.1% | 80.0% | 74.4% | 56.0% |
| 3 | Татварын ерөнхий газар | 70.1% | 82.0% | 74.4% | 53.9% |
| 4 | Төрийн худалдан авах ажиллагааны газар | 68.5% | 80.0% | 88.0% | 40.6% |
| 5 | Архивын ерөнхий газар | 67.1% | 80.0% | 78.4% | 43.0% |
| 6 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | 67.1% | 80.0% | 76.0% | 45.3% |
| 7 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 67.0% | 78.0% | 67.4% | 55.5% |
| 8 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 65.9% | 82.0% | 81.4% | 34.4% |
| 9 | Усны газар | 65.8% | 80.0% | 74.5% | 43.0% |
| 10 | Оюуны өмчийн газар | 65.7% | 78.0% | 77.0% | 42.2% |
| 11 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар | 63.3% | 78.0% | 67.3% | 44.5% |
| 12 | Гадаадын иргэн, харьяатын газар | 63.1% | 78.0% | 69.0% | 42.2% |
| 13 | Жижиг, дунд үйлдвэрийн газар | 63.0% | 78.0% | 68.0% | 43.0% |
| 14 | Улсын бүртгэлийн ерөнхий газар | 62.8% | 82.0% | 62.8% | 43.8% |
| 15 | Үндэсний геологийн алба | 61.9% | 82.0% | 63.2% | 40.6% |
| 16 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар | 61.7% | 78.0% | 67.3% | 39.8% |
| 17 | Цаг уур, орчны шинжилгээний газар | 61.1% | 82.0% | 61.6% | 39.8% |
| 18 | Боловсролын ерөнхий газар | 59.5% | 78.0% | 63.0% | 37.5% |
| 19 | Иргэний нисэхийн ерөнхий газар | 59.4% | 82.0% | 57.2% | 39.1% |
| 20 | Ашигт малтмал, газрын тосны газар | 59.1% | 82.0% | 55.3% | 39.8% |
| 21 | Соёл, урлагийн газар | 58.2% | 78.0% | 55.2% | 41.4% |
| 22 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | 57.9% | 82.0% | 44.8% | 46.9% |
| 23 | Гаалийн ерөнхий газар | 57.1% | 82.0% | 52.5% | 36.7% |
| 24 | Биеийн тамир, спортын улсын хороо | 56.7% | 80.0% | 49.4% | 40.6% |
| 25 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 56.1% | 78.0% | 51.2% | 39.1% |
| 26 | Мал эмнэлгийн ерөнхий газар | 43.5% | 78.0% | 52.5% | |
| | **Хэрэгжүүлэгч агентлагийн индекс** | **62.5%** | **79.8%** | **65.8%** | **41.9%** |
| | **Улсын цахим ил тод байдлын индекс** | **63.1%** | **78.8%** | **66.2%** | **44.2%** |

***Нийт үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагууд - 2022 он***

| [illegible] | [illegible] | 2022 оны индекс | 2021 оны индекс | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | Барилга хот байгуулалтын яам | 76.8% | 68.4% | 8.4% |
| 2 | Сангийн яам | 75.3% | 72.4% | 2.9% |
| 3 | Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам | 74.7% | 71.3% | 3.4% |
| 4 | Өвөрхангай аймаг | 74.6% | 76.6% | -2.0% |
| 5 | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | 72.6% | 69.8% | 2.8% |
| 6 | Цахим хөгжил харилцаа холбооны яам* | 71.0% | – | |
| 7 | Монгол Банк | 70.7% | 68.0% | 2.7% |
| 8 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 70.1% | 63.5% | 6.6% |
| 8 | Татварын ерөнхий газар | 70.1% | 65.4% | 4.7% |
| 9 | Төрийн худалдан авах ажиллагааны газар | 69.5% | 61.6% | 7.9% |
| 9 | Гадаад харилцааны яам | 69.5% | 53.8% | 15.7% |
| 10 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | 69.0% | 65.8% | 3.2% |
| 11 | Архивын ерөнхий газар | 67.1% | 64.5% | 2.6% |
| 11 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | 67.1% | 59.6% | 7.5% |
| 11 | Багануур дүүрэг | 67.1% | 67.0% | 0.1% |
| 12 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 67.0% | 70.3% | -3.2% |
| 13 | Хан-Уул дүүрэг | 66.8% | 74.7% | -7.9% |
| 14 | Санхүүгийн зохицуулах хороо | 66.7% | 65.7% | 1.0% |
| 15 | Жендэрийн үндэсний хороо | 66.6% | 64.8% | 1.8% |
| 16 | Засгийн газрын хэрэг эрхлэх газар | 66.5% | 61.6% | 4.9% |
| 17 | Үндэсний аудитын газар | 66.4% | 58.5% | 7.9% |
| 17 | Авлигатай тэмцэх газар | 66.4% | 67.0% | -0.6% |
| 18 | Чингэлтэй дүүрэг | 66.2% | 51.0% | 15.2% |
| 19 | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам | 66.1% | 61.5% | 4.6% |
| 20 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 65.9% | 53.5% | 12.4% |
| 20 | Байгаль орчин аялал жуулчлалын яам | 65.4% | 63.8% | 2.7% |
| 21 | Усны газар | 65.8% | 68.6% | -2.8% |
| 22 | Эрчим хүчний яам | 65.7% | 57.5% | 8.2% |
| 22 | Оюуны өмчийн газар | 65.7% | 59.4% | 6.3% |
| 23 | Цагдаагийн ерөнхий газар | 65.6% | 69.2% | -3.6% |
| 24 | Говьсүмбэр аймаг | 65.5% | 61.8% | 3.7% |
| 25 | Сонгинохайрхан дүүрэг | 65.4% | 63.9% | 1.5% |
| 26 | Монгол Улсын Их Хурал* | 65.2% | – | |
| 26 | Батлан хамгаалах яам | 65.2% | 62.5% | 2.7% |
| 27 | Өмнөговь аймаг | 64.9% | 72.0% | -7.1% |
| 28 | Баянгол дүүрэг | 64.4% | 62.5% | 1.9% |
| 28 | Увс аймаг | 64.4% | 59.1% | 5.3% |
| 29 | Төв аймаг | 64.3% | 48.9% | 15.4% |
| 29 | Дархан-Уул аймаг | 64.3% | 67.3% | -3.2% |
| 29 | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар | 64.3% | 59.6% | 4.7% |
| 30 | Онцгой байдлын ерөнхий газар | 64.1% | 68.8% | -4.7% |
| 30 | Зам тээврийн хөгжлийн яам | 64.1% | 65.1% | -1.0% |

Судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг судалгааны баг хүргүүлсэн байна.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нээлттэй мэдээллийн хүрээ, хангах үйл явц, үүрэг хариуцлага, хяналтын механизм, нөөц зэргийг тусгасан баримт бичиг, журмыг дотооддоо баталж мөрдүүлэх;
- Цахим хуудасны дизайн, технологийн шийдлүүд сайжирч байгаа боловч дотор нь байршуулж буй мэдээллийг ашиглахад хялбар байлгах тал дээр сайжруулах;
- Мэдээллийг цахим хэлбэрээр байршуулахдаа ямар нэг холбогдох хууль тогтоомжийг хангах үүднээс байршуулж байгаа ба хэрэглэгчийн өнцгөөс тэдэнд мэдээлэл хайх, хүлээн авахад хялбар байх талаас нь бодолцон сайжруулах

байдал сул багаа тул энэ чиглэлд холбогдох албан хаагчдыг чадавхжуулах шаардлагатай.

2022 оны төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс болон дэлгэрэнгүй тайланг Хараат бус судалгааны хүрээлэнгийн (IRIM) гүйцэтгэсэн тайлангаас үндэслэл болгон авсан болно. *Эх сурвалж: http://irim.mn/web-monitoring*

## 2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны жилийн эцсийн байдлаар https://shilendans.gov.mn/org/7600 шилэн дансны цахим системд төсөв/гүйцэтгэлийн ***8 төрлийн мэдээлэл 47, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл 45, бусад 6 төрлийн мэдээлэл 67 нийт 159*** мэдээллийг байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн байдал, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заасны дагуу мэдээллээ бүрэн илгээсэн байдал 2022 онд 1 мэдээллийг хоцроож хэрэгжилт ***99.35 хувьтай*** байна. *Эх сурвалж: https://www.shilendans.gov.mn/org/7600*

## 3. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасан “авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасан “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийн хүрээнд 62 нэгж үзүүлэлтүүдийг хамруулан 6 дахь удаагийн буюу 2022 оны “Шударга байдлын үнэлгээ”-ний судалгаагаар судалгаанд хамрагдсан 78 байгууллагаас ***76.5 оноогоор* XXIY байрт**, 31 агентлагуудаас **XIII байрт** эрэмбэлэгдэж, ***улсын (73.9 оноо) болон агентлагийн (73.9 оноо***) дунджаас дээгүүр байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны шударга байдлын үнэлгээ ***79.5 оноогоор эрэмбэлэгдэж***, 68 байгууллагаас **V байрт**, агентлагуудаас **III байрт** үнэлэгдэж байсан бол 2022 онд 3 оноогоор үнэлгээ буурсан байгаа нь гадаад шударга байдлын үнэлгээ 2021 онд 79.7 байсан бол 2022 онд 68.3 оноо болж -11.4 оноогоор буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна. Судалгааны үр дүнгээр Монгол улс дахь авлигын үндсэн шалтгаанд ил тод байх, цалин хөлс нэмэгдүүлэх, албан хаагчийн ёс зүй, хуулийн хэрэгжилт, зохицуулалтыг сайжруулах ажлуудыг хамгийн түрүүнд хийж хэрэгжүүлэх шаардлагатай гэж гэжээ.

*Эх сурвалж: https://iaac.mn/uploads/users/1279/files/Shudarga%20baidliin%20unelgee-2022%20on.pdf*

### Шударга байдлын үнэлгээ -2022 он







### *Шударга байдлын үнэлгээ – 2022*



## Гадаад шударга байдлын үнэлгээ – 2022 он

2022 оны хувьд төрийн байгууллагуудын гадаад шударга байдлын үнэлгээ нь 70.5 болж 2021 онтой харьцуулахад 3.5 оноогоор, агентлагуудын үнэлгээ 6.1 оноогоор тус тус өссөн үзүүлэлттэй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны гадаад шударга байдлын үнэлгээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад -11.4 өөр буурсан үзүүлэлттэй байна. Буурсан шалтгааны дэлгэрэнгүйг хүснэгт–2 оос тодорхой харж болно.

***Агентлагуудын гадаад шударга байдлын үнэлгээг 2021 болон 2022 онтой харьцуулсан байдал:***

***(Хүснэгт - 1)***

| № | Байгууллагын нэр | 2021 | 2022 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| | **Агентлагуудын ГШБҮ** | **66.4** | **72.6** | **6.2** |
| 18 | Мал эмнэлгийн ерөнхий газар | 59.0 | 72.0 | 13.0 |
| 19 | Татварын ерөнхий газар | 60.1 | 70.6 | 10.5 |
| 20 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 71.7 | 69.2 | -2.5 |
| 21 | Ашигт малтмал, газрын тосны газар | 61.8 | 68.4 | 6.7 |
| 22 | Тэрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 79.7 | 68.3 | -11.4 |
| 23 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 64.9 | 67.2 | 2.3 |
| 24 | Биеийн тамир, спортын улсын хороо | 69.3 | 64.9 | -4.4 |
| 25 | Үндэсний геологийн алба | 69.9 | 64.8 | -5.0 |
| 26 | Гаалийн ерөнхий газар | 52.9 | 63.9 | 11.0 |
| 27 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар | 68.0 | 63.4 | -4.6 |
| 28 | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар | 69.4 | 59.9 | -9.6 |
| 29 | Улсын бүртгэлийн ерөнхий газар | 46.4 | 59.0 | 12.6 |
| 30 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 62.4 | 53.2 | -9.2 |
| 31 | Боловсролын ерөнхий газар | - | 52.8 | - |

***(Хүснэгт – 2)***

| № | Байгууллагын нэр | Ил тод байдал | Хариуцлагатай байдал | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | Авлигын индекс | ГШБҮ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **ГШБҮ** | **60.4** | **67.3** | **63.8** | **60.7** | **89.7** | **80.8** | **77.1** | **70.5** |
| | **Яам** | **63.2** | **71.2** | **67.2** | **61.8** | **92.4** | **83.7** | **79.3** | **73.3** |
| 1 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 80.3 | 80.8 | 80.5 | 66.7 | 93.1 | 100.0 | 86.6 | 83.6 |
| 2 | Барилга, хот байгуулалтын яам | 40.1 | 57.7 | 48.9 | 48.8 | 60.1 | 65.7 | 58.2 | 53.5 |
| 3 | Батлан хамгаалах яам | 60.6 | 75.3 | 68.0 | 72.8 | 97.9 | 90.1 | 86.9 | 77.5 |
| 4 | Боловсрол, шинжлэх ухааны яам | 80.2 | 59.1 | 69.6 | 43.6 | 77.8 | 58.5 | 59.3 | 64.5 |
| 5 | Гадаад харилцааны яам | 56.8 | 86.9 | 71.8 | 67.2 | 100.0 | 92.9 | 86.7 | 79.3 |
| 6 | Зам, тээврийн хөгжлийн яам | 65.5 | 64.6 | 65.1 | 56.9 | 95.0 | 61.8 | 71.2 | 68.1 |
| 7 | Сангийн яам | 64.8 | 71.6 | 68.2 | 72.8 | 94.9 | 89.9 | 85.9 | 77.0 |
| 8 | Соёлын яам | 64.0 | 72.6 | 68.3 | 70.5 | 92.8 | 100.0 | 87.8 | 78.0 |
| 9 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | 67.6 | 67.1 | 67.3 | 51.2 | 97.1 | 64.6 | 71.0 | 69.1 |
| 10 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 59.6 | 70.0 | 64.8 | 72.9 | 95.5 | 92.4 | 86.9 | 75.9 |
| 11 | Хууль зүй, дотоод хэргийн яам | 54.6 | 69.4 | 62.0 | 65.3 | 97.0 | 91.4 | 84.6 | 73.3 |
| 12 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 70.0 | 76.3 | 73.1 | 74.9 | 100.0 | 97.5 | 90.8 | 82.0 |
| 13 | Эрүүл мэндийн яам | 60.5 | 59.9 | 60.2 | 48.8 | 90.5 | 60.8 | 66.7 | 63.5 |
| 14 | Эрчим хүчний яам | 70.6 | 71.4 | 71.0 | 57.0 | 92.2 | 85.9 | 78.3 | 74.7 |
| 15 | Цахим хөгжил, харилцаа холбооны яам | 42.7 | 92.0 | 67.3 | 75.0 | 100.0 | 100.0 | 91.7 | 79.5 |
| 16 | Эдийн засаг, хөгжлийн яам | 73.6 | 64.0 | 68.8 | 44.9 | 95.2 | 89.6 | 76.6 | 72.7 |
| | **Агентлаг** | **x** | **66.0** | **62.7** | **60.3** | **88.8** | **80.0** | **76.4** | **69.5** |
| 17 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 59.3 | 62.6 | 60.9 | 60.6 | 96.2 | 70.2 | 75.7 | 68.3 |
| 18 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 41.2 | 52.4 | 46.8 | 44.4 | 74.5 | 60.0 | 59.7 | 53.2 |

## Дотоод шударга байдлын үнэлгээ – 2022 он

2022 онд төрийн байгууллагуудын дотоод шударга байдлын үнэлгээ 82.2 болж өмнөх онтой харьцуулахад 1.0 оноогоор нэмэгдсэн ч агентлагуудын үнэлгээ буурсан байна. Дотоод шударга байдлын үнэлгээний үзүүлэлт нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс юм. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс нь хүний нөөц, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх тогтолцоо, удирдлагын хүсэл, эрмэлзэл зэрэг 5 бүлгийн нэгж үзүүлэлтээс хамаарна.

| № | Байгууллагын нэр | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2022* | | 81.4 | 69.6 | 75.3 | 96.2 | 92.2 | 87.4 | 98.7 | 73.6 | 84.5 | 82.2 |
| Яам | | 82.6 | 69.7 | 76.2 | 98.1 | 91.3 | 86.6 | 99.1 | 73.2 | 85.7 | 82.9 |
| 1 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 80.7 | 71.4 | 78.1 | 98.5 | 85.8 | 81.7 | 99.0 | 76.5 | [illegible] | [illegible] |
| 2 | Барилга, хот байгуулалтын яам | 85.6 | 71.6 | 78.6 | 99.4 | 98.5 | 83.1 | 98.5 | 75.6 | [illegible] | [illegible] |
| 3 | Батлан хамгаалах яам | 89.5 | 82.6 | 85.5 | 99.3 | 89.2 | 95.5 | 100.0 | 86.6 | [illegible] | [illegible] |
| 4 | Боловсрол, шинжлэх ухааны яам | 81.7 | 62.6 | [illegible] | 97.3 | 97.3 | 79.7 | 100.0 | 71.6 | [illegible] | [illegible] |
| 5 | Гадаад харилцааны яам | 82.1 | 73.0 | 77.6 | 96.5 | 96.0 | 88.5 | 99.0 | 74.1 | [illegible] | [illegible] |
| Агентлаг | | 81.2 | 69.2 | 74.7 | 95.6 | 91.6 | 88.0 | 98.7 | 73.0 | 83.8 | 81.6 |
| 17 | Төрийн албаны бодлого, зохицуулалтын газар | 81.1 | 70.4 | 75.6 | 98.7 | 97.9 | 91.6 | 100.0 | 72.7 | 80.2 | [illegible] |
| 18 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 82.3 | 65.1 | 72.7 | 87.1 | 98.9 | 78.2 | 99.0 | 65.1 | 84.5 | [illegible] |
| 19 | Онцгой байдлын ерөнхий газар | 86.1 | 73.8 | 80.0 | 98.5 | 98.5 | 91.8 | 100.0 | 74.7 | 82.7 | [illegible] |
| 20 | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар | 84.2 | 80.5 | 81.3 | 99.3 | 98.8 | 96.3 | 100.0 | 80.2 | [illegible] | [illegible] |

## Бодлогод оролцогчдын үнэлгээ – 2022 он

Бодлогын оролцогчдын үнэлгээний 2022 оны үнэлгээ 77.3 хувьтай байна.

| № | Байгууллагын нэр | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | БОТ |
|---|---|---|---|---|---|---|
| Бодлогод оролцогчдын үнэлгээ | | 73.7 | 49.0 | 94.3 | 59.8 | 69.0 |
| Яам | | 70.9 | 47.0 | 93.1 | 57.8 | 67.1 |
| 1 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 59.2 | 33.0 | 75.5 | 30.1 | 49.5 |
| 2 | Барилга, хот байгуулалтын яам | 64.4 | 51.1 | 90.4 | 52.6 | 64.6 |
| 3 | Батлан хамгаалах яам | 83.0 | 49.5 | 98.3 | 63.3 | 73.0 |
| 4 | Боловсрол, шинжлэх ухааны яам | 57.4 | 48.6 | 86.9 | 48.3 | 60.3 |
| 5 | Гадаад харилцааны яам | 77.9 | 35.1 | 100.0 | 64.9 | 69.5 |
| 6 | Зам, тээврийн хөгжлийн яам | 83.9 | 64.4 | 100.0 | 59.6 | 77.0 |
| 7 | Сангийн яам | 64.2 | 35.5 | 95.0 | 47.2 | 60.5 |
| 8 | Соёлын яам | 85.9 | 47.2 | 98.1 | 72.6 | 76.0 |
| 9 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | 74.1 | 47.3 | 93.6 | 55.4 | 67.6 |
| 10 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 71.0 | 44.7 | 98.0 | 56.8 | 67.6 |
| 11 | Хууль зүй, дотоод хэргийн яам | 47.5 | 46.7 | 85.0 | 51.5 | 57.7 |
| 12 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 68.9 | 52.6 | 91.6 | 61.3 | 68.6 |
| 13 | Эрүүл мэндийн яам | 51.0 | 39.0 | 90.6 | 45.9 | 56.6 |
| 14 | Эрчим хүчний яам | 83.7 | 55.9 | 96.7 | 73.3 | 77.4 |
| 15 | Цахим хөгжил, харилцаа холбооны яам | 72.0 | 42.0 | 91.8 | 61.5 | 66.8 |
| 16 | Эдийн засаг, хөгжлийн яам | 90.7 | 59.5 | 100.0 | 75.0 | 81.3 |
| Агентлаг | | 80.5 | 50.8 | 96.7 | 61.8 | 72.4 |
| 17 | Төрийн албаны бодлого, зохицуулалтын газар | 95.1 | 53.5 | 100.0 | 60.7 | 77.3 |
| 18 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 80.2 | 54.8 | 97.1 | 54.5 | 71.6 |
| 19 | Онцгой байдлын ерөнхий газар | 89.0 | 31.4 | 100.0 | 59.8 | 70.0 |
| 20 | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар | 92.1 | 63.8 | 100.0 | 66.8 | 80.7 |
| 21 | Стандарт, хэмжил зүйн газар | 75.0 | 35.2 | 95.8 | 64.8 | 68.0 |
| 22 | Цаг уур, орчны шинжилгээний газар | 80.1 | 27.6 | 100.0 | 48.0 | 63.9 |
| 23 | Гаалийн ерөнхий газар | 60.2 | 38.6 | 72.9 | 53.8 | 56.4 |
| 24 | Татварын ерөнхий газар | 62.1 | 49.5 | 100.0 | 60.6 | 68.1 |
| 25 | Цагдаагийн ерөнхий газар | 73.6 | 52.0 | 94.7 | 57.3 | 69.4 |
| 26 | Улсын бүртгэлийн ерөнхий газар | 92.2 | 52.4 | 100.0 | 62.5 | 76.8 |

***Монгол Улс дахь авлигын шалтгаан, нөхцөл***

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцээр Эрүүл мэнд, Шүүх, Газрын алба, Гааль, Цагдаагийн газрыг нэрлэсэн байна. 2021 онтой харьцуулахад дээрх байгууллагуудын эрэмбэ огт өөрчлөгдөөгүй байна.

Авлигын шалтгаан нөхцөлд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл нь албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигладаг, цалин орлого бага, төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их шаарддаг гэж судалгаанд оролцогчдын 64.7 хувь нь хариулсан байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын гадаад шударга байдлын үнэлгээний өөрчлөлт 2021 оны үр дүнгээс их байгаа нь 2022 оны байгууллагын эрэмбийг хойш татсан гэж үзэж болохоор байна.

Иймд байгууллагын үйл ажиллагааг илүү нээлттэй, ил тод мэдээлэх, хариуцлагатай байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатайг судалгааны үр дүн харуулж байна.

## 3. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ



Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар хамтран ажиллагч байгууллагууд хэрхэн үнэлж дүгнэж байгааг тандан судалж, дүн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6. Засгийн газар Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг зохион байгуулна гэж заасныг удирдлага болгон “Хэрэглэгчийн үнэлгээ”-г үйлчилгээ үзүүлдэг харьяа байгууллагуудаас цахимаар болон цаасаар салбар, чиг үүрэг, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 15 асуулгын хүрээнд 63 иргэнээс санал асуулгыг авч дүн нэгтгэлээ.

***Судалгааны үр дүн:***

Салбар, чиг үүрэг, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 15 асуулгын хүрээнд 63 иргэнээс санал асуулгыг цаасаар болон цахимаар https://docs.google.com/forms/d/15Y0kbZ_xdH5KwIZzFZaq4qqOEtIR0ZQpxJWq7jHDCtw/edit?pli=1 google form ашиглан 21 хоногийн хугацаанд хамтрагч байгууллагуудын захирал, нягтлан бодогч мэргэжилтнүүдийг оролцуулан авсан.

Судалгааг ил тод, шударга зохион байгуулах үүднээс судалгаанд оролцогч иргэний хувийн мэдээллийг шаардахгүйгээр зохион байгуулав.

Судалгаанд оролцсон 63 иргэний 33 иргэн буюу 53.2 хувь нь төрийн өмчит хуулийн этгээд, 12 иргэн буюу 17.7 хувь нь төрийн захиргааны, 11 иргэн буюу 16.1 хувь нь бусад буюу хувийн хэвшил, 5 иргэн буюу 6.4 хувь нь төрийн тусгай, 2 буюу 1.6 хувь нь төрийн үйлчилгээний байгууллагад ажил эрхэлдэг иргэд байв.

Судалгааны дүнгээр 57 иргэн буюу 90.5 хувь нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун гэсэн хариултыг өгсөн байгааг дүгнэхэд байгууллагын үйл ажиллагаанд судалгаанд оролцсон иргэдийн өгсөн дундаж оноо 4.5 буюу сайн гэж дүгнэсэн байна.

Мэдээллийн хангалттай, ил тод, хүртээмжтэй, шуурхай байдлын талаар (асуулт 7, 8, 9) судалгаанд оролцогчдын 86.2 хувь нь сайн буюу 4.0 оноогоор үнэлсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын харилцаа, хандлага, хариуцлагатай, шударга байдалд (асуулт 11, 12, 13, 15) судалгаанд оролцогчдын 90.2

хувь нь маш сайн, сайн, 9.8 хувь нь дунд гэж өгсөн бөгөөд дундаж оноо 4.3 буюу сайн гэж дүгнэсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар үйлчлүүлэхдээ хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чаддаг уу гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 4.2 хувь нь хүссэн үйлчилгээгээ хагас дутуу авсан, 2.1 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй, 2.1 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй бөгөөд үйлчлэхээс татгалздаг гэж хариулсан, мэдээллийн ил тод, нээлттэй, хангалттай байдалд 13 хувь нь дунд, үйлчилгэг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх, талаар энгийн ойлгомжтой байдалд 15 хувь нь дунд, хандсан асуудлын хүрээнд шаардлагатай зөвлөгөөг авах боломжтой байдалд 15 хувь нь дунд, санал, гомдол илэрхийлэх нээлттэй байдалд 9 хувь нь дунд, 6 хувь нь муу гэж үнэлснээс үзэхэд байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд сурталчлах, мэдээллийн нээлттэй ил тод, хангалттай байдалд илүү анхаарч, сайжруулах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

-----o O o-----

## ОНЦЛОГ АЖЛУУД

### Төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн засаглалын хүрээнд:



Засгийн газрын 2022 оны “Хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” 124 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 108 дугаар тогтоолоор хууль бусаар хувьчлагдсан Хөтөл цемент шохойн үйлдвэрийг төрийн өмчид хүлээн авсан.



Засгийн газрын 2022 оны “Концессын гэрээ цуцлах тухай” 148 дугаар тогтоол, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн эрх шилжүүлэн авах үйл ажиллагаа болсон.

Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, олон нийтийн компани болгох зорилгоор тодорхой хувийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй, ил тод, шударгаар арилжих замаар ***Төрийн банк*** анхлан нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн.






Төрийн хэмнэлтийн тухай хууль, Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолуудын хүрээнд дараах төрийн өмчит компаниудын 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар шийдвэрлэсэн. Үүнд:



***"Төрийн өмчит компанийн шинэчлэл – IPO"*** сэдэвт сургалтыг төрийн өмчит компаниудын төлөөлөлд зориулан зохион байгуулсан. IPO буюу "Initial Public Offering" гэдэг олон нийтэд хувьцаагаа анх удаа хөрөнгийн биржээр дамжуулан худалдах үйл ажиллагааг хэлдэг. IPO нь үр дүнтэйгээр хэрэгжсэнээр хөрөнгийн өгөөж өсөж, компанийн засаглал сайжирч, олон нийтийн хяналт, тогтолцоо бий болох зэрэг нийгэм, эдийн засагт олон давуу тал ач холбогдолтой болно.





## Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.1-д "чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх...." гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 хуулийн этгээдийн 104 тэргүүн дэд, дэд дарга, орлогч дарга, зөвлөхийн албан тушаалыг тухайн хуулийн этгээдийн зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтаас хасах арга хэмжээ авч, албан тушаалтнуудыг чөлөөлсөн. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тэргүүн дэд, дэд, орлогч дарга нарын орон тоог цомхотгосонтой холбоотой цалин хөлсний зардлыг 4.0 тэрбум төгрөгөөр, тэдгээрийн жолооч, туслахын орон тоо хасагдсанаар цалин, унааны зардал 1.6 тэрбум төгрөгөөр, нийт 5.6 тэрбум төгрөгийн хэмнэлт гарч байна.

Төрийн хэмнэлтийн хууль батлагдан гарсантай холбогдуулан төрийн байгууллагад шинээр автомашин худалдан авахыг зогсоосон бөгөөд төрийн байгууллагын эзэмшилд байгаа ашиглалтгүй, илүүдэлтэй, зөвшөөрсөн тоо хэмжээнээс илүү авто тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлж, шилжүүлэх, худалдах ажлыг зохион байгуулж байна.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2022 онд нийт 427 автомашиныг үзлэгт оруулан, төлбөр, торгууль, чанар байдлыг шалган актаар баталгаажуулан татан төвлөрүүлж, Засгийн газрын авто бааз болон төрийн байгууллагын авто гаражид байршуулсан.

Татан төвлөрүүлсэн автомашинаас Засгийн газрын 2022

оны 204 дүгээр тогтоолын дагуу эхний ээлжид дуудлагын үйлчилгээнд ашиглуулахаар 65 автомашиныг Засгийн газрын Авто баазад шилжүүлж дуудлагын үйлчилгээнд ашиглах боломжоор хангасан.

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойш тус хуулийн 6.5-д заасан цагдаа, онцгой, батлан хамгаалах, хүн эмнэлэг, мал эмнэлэг, шүүх, шүүхийн шийдвэр, хил, гааль зэрэг байгууллагуудад нийт 114 автомашиныг ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар шилжүүлсэн.

Татан төвлөрүүлсэн автомашинаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нийт 161 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн. Өдөр тутмын сонин болон веб сайтуудад нийтэд ил тод зарлан дуудлагын худалдааг зохион байгуулж 2022 онд нийт 888.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Автомашиныг ийнхүү татан төвлөрүүлснээр тэдгээртэй холбоотой тухайн жилд гарах шатахуун, гараж, жолоочийн цалин, татвар, даатгалын зардлууд болох нийт 3.5 тэрбумын төгрөгийн зардлыг хамгийн багадаа хэмнэх боломж бүрдсэн.

| № | Татан төвлөрүүлсэн автомашины хуваарилалт | Нийт |
|---|---|---|
| 1 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан цагдаа, хил, онцгой, эрүүл мэнд зэрэг байгууллага болон автомашин ашиглах эрх бүхий байгууллагад төрийн байгууллагад шилжүүлсэн тоо | 114 |
| 2 | Засгийн газрын автобааз ТӨҮГ-т дуудлагын журмаар шилжүүлсэн автомашин | 65 |
| 3 | Худалдахаар шийдвэрлэсэн, нээлттэй худалдсан, худалдаж байгаа | 161 |
| | Нийт | 340 |

**Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын хүрээнд:**



Төрийн өмчийн улсын үзлэг тооллого, төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын “НЭГДСЭН СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨН”-ийг Орхон аймагт 21 аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газрын албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Мөн орон нутгийн өмчийн газруудад очиж улсын үзлэг тооллого, зохин байгуулах, мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамжийг нэвтрүүлэх, мэдээллээр дүүргэх талаар арга зүйн зөвлөгөөг 5500 гаруй байгууллагын нягтлан бодогч, нярав, аж ахуйн ажилтнуудад өгсөн.









Төрийн болон орон нутгийн өмчийн нийт 6814 нэгж хамрагдсанаас хуулийн этгээдийн гэрчилгээтэй 5484 байгууллага байна. Эдгээрийн зохион байгуулалтын хэлбэрээр нь ангилан үзвэл төсөвт байгууллага 4733, хувьцаат компани 68, хязгаарлагдмал хариуцлагатай компани 99, төрийн өмчит болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 357, банк 3 (ХХК), төрийн тусгай сан 20, өрхийн эмнэлэг 204 байна. Улсын үзлэг, тооллогод нийт 91.7 их наяд төгрөгийн хөрөнгө хамрагдсанаас 39.7 их наяд төгрөгийн төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө байна.



Төрийн болон орон нутгийн улсын үзлэг тооллогоор Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газартай хамтран анх удаа ХУР системийн программаас шууд татан тухайн байгууллагын нэр дээрх газар эзэмших эрхийн тулган баталгаажуулалт хийж, тайлбар дүгнэлт гарган ажилласан.




Энэ удаагийн үнэлгээнд нийт **19,325** нэгж талбарын **80,117.61** га газар хамрагдаж нийт **6.1 их наяд** төгрөгөөр үнэлэгдсэн ба үүнээс биет бус хөрөнгийн балансын үнээс газрын балансын үнэ 34 хувийг эзэлж байна.



Хүснэгтээс харахад газрыг гараас оруулсан нь цахимд системд ороогүй бөгөөд газрын гэрчилгээг Э-дугааргүй буюу QR кодтой болгох шаардлагатайг харуулж байна. Мөн ХУР-аас татсан ч Э-дугааргүй нь газрын цахим системд зөрчилтэйг харуулж байгаа ба дээрх зөрчлийг газрын газрын цахимд системд оруулж тухайн аймаг, дүүрэг, сумын газрын албанд хүргүүлж гэрчилгээг шинэчлэх шаардлагатай.



Хууль, эрх зүйн үндэслэлтэй нотолгоонд суурилан, шинжлэх ухааны арга, аргачлалд тулгуурлах зарчмыг баримтлах зорилгоор дараах судалгааны ажлуудыг хийв.

Төрийн өмчит хуулийн этгээдүүдэд төлөөлөл хэрэгжүүлдэг нийт 72 компанийн 60 нь төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаагаа явуулж байна. ***Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоон судалгааг*** гаргахад нийт 535 гишүүн ажиллаж байгаагаас хараат бус 169 гишүүн байна.







Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого зохион байгуулсантай холбогдуулан дараах судалгааг хийж мэдээллийн санг үүсгэсэн баяжуулав.

***Төрийн өмчийн Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн судалгаа***

Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг Улсын батлах хамгаалах, Аюулгүй байдлыг хангах, нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын болон масштабын байр зүйн зургаар зурагжуулах энэ талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгуулдаг бөгөөд Геодези, зураг зүйн тухай хуулиар төрийн өмч гэж заасан байдаг.

Геодези зураг зүйн нэгдсэн санд 4 төрлийн геодезийн сүлжээний 21452 ширхэг цэг, тэмдэгтийн судалгаа гарчээ. Үүнд: Трангуляци, полигонометрийн 15136, Өндрийн 5442, Гравиметрийн 128, GPS-ийн 843 цэг тэмдэгт орж байна.




***Тооллогоор илэрсэн зөрчилтэй хөрөнгийн судалгаа***

| № | Бүртгэлгүй хөрөнгө | Тоо ширхэг | Үнийн дүнгээр (сая.төг) |
|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн өмчийн дүн | 1,222,886 | 356,963.29 |
| 2 | Төрийн өмчийн дүн | 1,357 | 1,638.05 |
| | Нийт дүн | 1,224,243 | 358,601.35 |

Бүртгэлгүй хөрөнгө
358,801.35 сая төгрөг

Дутагдсан хөрөнгө
4,861.1 сая төгрөг

| № | Дутагдсан хөрөнгө | Тоо ширхэг | Үнийн дүнгээр (сая төг) |
|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн өмчийн дүн | 28,669 | 2,625.5 |
| 2 | Төрийн өмчийн дүн | 95 | 2,235.6 |
| | Нийт дүн | 28,764 | 4,861.1 |

Илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгө 740,121.8 сая төгрөг

| № | Илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгө | Үнийн дүнгээр (сая төг) |
|---|---|---|
| 1 | Орон нутгийн өмчийн дүн | 272,418.5 |
| 2 | Төрийн өмчийн дүн | 467,703.3 |
| | Нийт дүн | 740,121.8 |

Маргаантай хөрөнгө
41,270.72 сая төгрөг

| № | Маргаантай хөрөнгө | Тоо ширхэг | Үнийн дүнгээр (сая төг) |
|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн өмчийн дүн | 1109 | 28,107.09 |
| 2 | Төрийн өмчийн дүн | 4006 | 13,163.63 |
| | Нийт дүн | 5115 | 41,270.72 |

***Барилгагүй бөгөөд түрээсийн байранд байрладаг байгууллагын судалгаа***



Өөрийн эзэмшлийн байргүй, төрийн болон орон нутгийн өмчийн нийт **772** байгууллага байна. Үүнд орон нутгийн өмчийн **234,** төрийн өмчийн **538** байгууллага орж байна.

Тэдгээр байгууллага нь нийт 81,744.41 м.кв талбай бүхий байрыг жилийн 12,582.5 сая төгрөгөөр түрээслэж, 462 гэрээ байгуулсан байна.

| № | [illegible] | Байгууллагын тоо | Түрээс түрээсийн харилцаа | | | Түрээсэлж буй талбай (м.кв) | Түрээсийн төлбөр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ашиглалтын зардалтай түрээсийн төлбөртэй | зөвхөн ашиглалтын зардалтай | төлбөргүй | | сарын төлбөр (сая төг) | Жилийн төлбөр (сая төг) |
| А | Төр | 538 | 462 | 32 | 44 | 81744.41 | 1,048.54 | 12,582.54 |
| Б | Орон нутаг | 234 | 112 | 45 | 216 | 45,196.80 | 639.58 | 7,674.68 |
| Нийт дүн | | 772 | 574 | 77 | 260 | 126,941 | 1,688.15 | 20,257.21 |

***Агаарын орон зай ашиглаж буй радио долгионы судалгаа***

Радио долгионыг ашиглан үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээний төрлийг ангилан харуулбал:

| Техникийн төрөл | Тусгай зөвшөөрлийн тоо | Эзэмшигч байгууллагууд | Жилийн нийт төлбөрийн хэмжээ (төгрөг) |
|---|---|---|---|
| ҮХС Гар утасны холбоо | 27 | Мобиком ХХК, Юнител ХХК, Жи Мобайл ХХК, Скайтел ХХК, Скаймедиа ХХК | 3,570,235,000.00 |
| Телевизийн нэвтрүүлэг [illegible] | 33 | Радио телевизийн сүлжээ УТҮГ, Монголын цахилгаан холбоо ХК болон бусад хувийн компаниуд | 196,680,000.00 |
| Радио богино долгион, [illegible] | 128 | Радио телевизийн сүлжээ УТҮГ, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК, Мобиком ХХК, Юнител ХХК, Жи Мобайл ХХК, Скайтел ХХК, бусад хувийн компаниуд | 550,624,653.00 |
| Нийт | 188 | | 4,317,539,653.00 |

***Газрын хэвлий дэх баялаг, ашигт малтмалын судалгаа***

Газрын хэвлий дэх баялаг, ашигт малтмалын судалгаанаас харахад металл ашигт малтмалын 1110 орд, 1327 тусгай зөвшөөрөл, металл бус ашигт малтмалын 345 орд, 312 тусгай зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмалын 341 орд, 237 тусгай зөвшөөрөл, шатах тосох малтмалын 8 орд, 5 тусгай зөвшөөрөл нийт 1804 орд, 1881 тусгай зөвшөөрөл байна.

| № | Хуулийн этгээдийн нэр | Зөвшөөрлийн тоо | Гектар талбай |
|---|---|---|---|
| Төрийн өмчит | | | |
| 1 | "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК | 3 | 1,663.00 |
| 2 | "Монголросцветмет" ТӨҮГ | 27 | 15,982.61 |
| 3 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ | 7 | 27,396.13 |
| 4 | "Эрдэнэс таван толгой" ХК | 8 | 68,471.43 |
| 5 | "Эрдэнэт силвер ресурс" | 1 | 2,887.85 |
| Нийт | | 46 | 116,401.02 |
| Орон нутгийн өмчит | | | |
| 1 | "Таван толгой" ХК | 1 | 276.9 |
| 2 | "Баянтээг" ХК | 1 | 581.74 |
| Нийт | | 2 | 858.64 |
| Нийт дүн | | 48 | 117,229.46 |

### *Төрийн өмчийн үр ашгийн байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа*

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хууль бус шийдвэрийн улмаас халагдсан ажилтнуудад төрийн болон төрийн өмчит ХК, ТӨҮГ-ын төсвөөс олгосон нөхөн олговор, түүнийг холбогдох хуулийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн талаарх судалгааг нийт 48 хуулийн этгээдэд хүргүүлж ажиллан нийт 2.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн тухай судалгааг;

Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн өр, төлбөрийн харьцуулсан судалгаа, урьдчилж төлсөн төлбөр, богино урт хугацаат зээл, хүү, өглөг, хуримтлагдсан ашиг, шилжүүлсэн зээл, хөрөнгийн судалгааг;

2021 онд "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь 1250 ширхэг худалдан авалт хийгдээгүй вагоны түрээсийн урьдчилгаа төлбөрт 10.78 тэрбум төгрөгийг төлсөн байгаа дээрх боломжийг түрээсийн бус хөрөнгө оруулалтаар шийдсэн бол ашгийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх боломжтой байсан талаар дүн шинжилгээ, судалгааг;

"Кью Эс Си" ХХК-иас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-д түрээслүүлсэн 2014-2022 оны эхний улирлын байдлаарх машин механизм, тээврийн хэрэгсэл, үйлдвэрийн түрээсийн гэрээнд дүн шинжилгээ хийж 18.5 тэрбум төгрөгийг түрээсийн төлбөрөөс илүү төлсөн болохыг тогтоосон.

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ГАНБОЛД

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ

## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

**(2022 он)**

2023.03.15 Улаанбаатар хот

<table>
<tr><th colspan="2">Үзүүлэлт</th><th>Хувь</th><th>Жин</th><th>Оноо</th></tr>
<tr><th>1</th><th>2</th><th>3</th><th>4</th><th>5</th></tr>
<tr><td rowspan="4">Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ</td><td>1.“Алсын хараа – 2050” бодлогын баримт бичиг</td><td>90.0%</td><td rowspan="4">0.6</td><td rowspan="4">53.7</td></tr>
<tr><td>2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт</td><td>91.6%</td></tr>
<tr><td>3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт</td><td>81.7%</td></tr>
<tr><td>4.Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт</td><td>95.0%</td></tr>
<tr><td rowspan="2">Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ</td><td>1.Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт</td><td>98.6%</td><td rowspan="2">0.2</td><td rowspan="2">19.9</td></tr>
<tr><td>2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт</td><td>100.0%</td></tr>
<tr><td rowspan="4">Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ</td><td>1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ</td><td>65.9%</td><td rowspan="4">0.2</td><td rowspan="4">16.6</td></tr>
<tr><td>2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ</td><td>99.4%</td></tr>
<tr><td>3.Шударга байдлын түвшний үнэлгээ</td><td>76.5%</td></tr>
<tr><td>4.Хэрэглэгчийн үнэлгээ</td><td>90.5%</td></tr>
<tr><td colspan="2">Ерөнхий үнэлгээ:</td><td>88.9%</td><td>1.0</td><td>90.2</td></tr>
</table>

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР